



## ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 дугаар сарын 14 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын Х хуралдааныг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 27 гишүүнтэй 96,3 % ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаагийн мэдээллийг сонслоо.

2. Хилийн Баянхошуу боомтоор БНХАУ-аас 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Монгол Улсын 4 иргэн нэвтэрч орох хүсэлт гаргасныг хэлэлцэв.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 62, 63 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат танилцуулав.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, Д.Мөнхтуяа, Хилийн 0198 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Эрдэнэчулуун нарт:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 63 дугаар тогтоолын дагуу БНХАУ-аас Монгол Улсын 4 иргэн хилийн Баянхошуу боомтоор 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр орох хүсэлт гаргасаны дагуу халдварын хяналт сэргийлэлтийн журмын дагуу ариутгал халдваргүйтгэл хийж нэвтрүүлэх;

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад:

1. "Шуурхай штаб байгуулах тухай" аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж танилцуулах;

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн, Ч.Оюунаад:

1. Хилээр нэвтэрч орж ирсэн Монгол Улсын 4 иргэнийг Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн автомашинаар эмчийн хяналтын дор тээвэрлэж Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт шилжүүлэх;

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж танилцуулах;

Аймгийн Онцгой комиссын гишүүдэд:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд аймгийн Онцгой комиссын гишүүд холбогдох аж ахуй нэгж, байгууллагын удирдлагууд холбоо барих бэлэн байдлыг хангах, албан томилолтоор болон хувийн ажлаар гадагш явах тохиолдолд аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад мэдэгдэж байхыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА Ч.ГАНБАТ



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА